

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ШИНЭЧИЛСЭН ХЯНАЛТЫН КАРТ

2017.05.09

Алтай хот

Д/д	№	Тогтоолын нэр	Батлагдсан шийдвэр		Заалтын		Хариуцах хэлтэс, агентлаг
			Огноо	дугаар	дугаар	тоо	
		ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН НЭР, ЗААЛТЫН АГУУЛГА					
1	1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай. 4. Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2017.01.04	6	4	1	ТЗУХ, БОАЖГ,
2	2	Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай. 4. Улсын нөөцөөс үнэгүй болон хямдралтай үнээр олгосон өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй байх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллан, олгосон хөрөнгийг хавсралтад заасны дагуу зарцуулан гүйцэтгэлийн тайланг гаргаж, холбогдох баримтын хамт 2017 оны 5 дугаар сард багтаан ОБЕГазарт хүргүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	2017.01.11	7	4	1	ХХААГ, ОБГ
3	3	Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 4. Мах боловсруулах үйлдвэр, зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжид малчдаас мал, мах худалдан авах үйл ажиллагааг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хяналт тавьж ажиллах	2017.01.11 /2017.01.26	14	4	1	ХОХБТХ, ХХААГ
4	4	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай. 3. Хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авах.	2017.01.18 /2017.03.06	24	3	1	НБХ, ЭМГ
5	5	Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай. 2. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа байдалд МХЕГ, ТЕГ хамтран 2017 онд багтаан хяналт шалгалт хийж дүнг танилцуулах.	2017.02.01	46	2	1	ХОХБТХ ХЭЗХ, МХГ, Татварын хэлтэс, СХЗХ,
6	6	Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай 2. “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд,	2017.02.08 /2017.03.20	47	2	1	ХОХБТХ

		аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.					
7	7	Улсын аварга малчин, хошой аврга малчин, саальчин, фермер, тариаланч хамт олон хамт олон шалгаруулах тухай 1.Болзлын шаардлага хангасан 5 “Улсын аварга малчин”, 1“Улсын хошой аварга малчин”, 1 “Улсын аварга тариаланч” шалгарсан байна.	2017.02.08 /2017.02.21	49	1	1	ХХААГ
8	8	Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай 3.Цэргийн албыг дүйцүүлэн хаалгах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2017.02.08	51	3	1	Цэргийн штаб
9	9	Хурдан морины бүсийн уралдааны 2017 оны хуваарийг тогтоох тухай. 1.Хаврын бүсийн хурдан морины уралдааныг 2017.03.12-ны өдөр Говь-Алтай, Хөвсгөл аймагт зохион байгуулах.	2017.02.22 /2017.03.09	63	1	1	ТЗУХ, НБХ
10	10	Дүрэм батлах тухай. “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.	2017.03.07	68	2	1	ХОХБТХ, ГХБХБГ
11	11	Дүрэм батлах тухай. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.	2017.03.07	69	2	1	ХОХБТХ, ГХБХБГ
12	12	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай. 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын зээл тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.	2017.03.07 2017.04.17	77	1	1	ХЭЗХ, Цагдаагийн газар
13	13	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай. 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.	2017.03.07	78	2	1	НБХ, ЭМГ
14	14	Журам шинэчлэн батлах тухай. 2.“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-г үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг үүрэг болгосугай.	2017.03.15	89	2	1	ХШҮДАХ
15	15	Хөтөлбөр батлах тухай. 3.“Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.	2017.03.20	98	3	1	БОАЖГ

16	16	Иргэнд 2017 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай. 2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.	2017.03.29	104	2	1	ХОХБТХ, ГХБХБГ
17	17	Журам батлах тухай. 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2017.04.12	111	2	1	ХОХБТХ, ХЭЗХ
18	18	Үндэсний хөтөлбөр батлах тухай. 3.“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн болон Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2017.04.12	112	3	1	НБХ, ЭМГ
19	19	Концессын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай. 1. Дараах арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай: 1) концессын зүйлийн жагсаалтад “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр тусгасан улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээг 2018 оны төсвийн жил хүртэл аливаа этгээдтэй байгуулахгүй байх; 2) улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй, концессын гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх; 3) концессын гэрээ байгуулах замаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр үүсгэхгүй байх; 4) концессын гэрээ байгуулсан боловч ажил нь эхлээгүй гэрээний үйлчлэлийг зохих журмын дагуу зогсоох; 5) шинээр концессын гэрээний дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг хүлээхгүйгээр, улсын болон орон нутгийн төсөвт төлбөрийн ачаалал үүсгэхгүйгээр концессын бусад төрлөөр хэрэгжүүлж ажиллах.	2016.08.17	37	1	5	СТСХ, ХОХБТХ
20	20	Монгол Улсын 2016 оны төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд авах зарим арга хэмжээний тухай. 1. Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн эхний долоон сарын төсвийн гүйцэтгэлийг үндэслэн төсвийн жил дуусах хүртэлх хугацаанд дор дурдсан арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай: 1) төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, бүх шатны төсвийн	2016.08.17	38	1	5	СТСХ, ХОХБТХ, ОНӨГ

		байгууллагын зарцуулагдаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, гадаад, дотоод томилолт, зочин, төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал, хангамж, бараа материалын болон сургалтын зардал, сурталчилгааны зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад төсвөөс олгох татаас, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардал, бараа, үйлчилгээний бусад зардал, гэрээ байгуулаагүй, эсхүл байгуулсан боловч ажил нь эхлээгүй бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг бууруулан зайлшгүй шаардлагатай зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх; 2) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зарлахгүй, гэрээ байгуулахгүй байх; 3) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө гэрээ байгуулсан боловч худалдан авалт нь эхлээгүй арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу зогсоох; 4) улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шинээр зохион байгуулахгүй байх; 5) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар гэрээ нь байгуулагдаагүй, ажлын гүйцэтгэл гараагүй, удаашралтай байгаа барилга байгууламжийн санхүүжилтийг зохих журмын хойшлуулах.					
21	21	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам батлах тухай. 2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2016.03.14	153	2	1	ХОХБТХ ХХААГ
22	22	“Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр батлах тухай. 3. Эрхэлсэн ажлынхаа хүрээнд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдэд оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг тусгаж, зохион байгуулах арга хэмжээнд оюутны оролцоог ханган үйлдвэр, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжид оюутныг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах. 4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан танилцуулж байх. 5. “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг үйлдвэр, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.	2016.12.07 /2017.03.30	178	3, 4, 5	3	НБХ, БСУГ, ХХҮХ, АШУҮИС-ийн салбар, МСҮТ
23	23	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулах. 3.Концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам, гүүрийн байгууламж, тоног төхөөрөмж болон бусад концессын зүйлийг хүлээн авч, төрийн өмчийн бүртгэлд тусгах. 4.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө /барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, зураг төсөл, төлөвлөгөө зэрэг/-г орон нутгийн өмчийн	2016.12.21 /2017.01.04	193	1, 3, 4, 7, 8	5	ХОХБТХ, СТСХ, ОНӨГ

		бүртгэлд бүртгэх. 7. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31, 70.3-т заасны дагуу шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх. 8. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах, дуусаагүй барилга байгууламжийг судлан, зохих шийдвэр гаргах.					
24	24	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм батлах тухай. 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	2016.12.21	200	2	1	НБХ, ХХҮГ
25	25	Журам батлах тухай 3.Улсын аварга болон хошой аварга малчин, фермер, саальчин, тариаланч хамт олон ба тариаланч шалгаруулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэртээ малчдыг малын чанар, ашиг шимийн үзүүлэлт, тэдний нийгэмд үзүүлж байгаа хувь нэмэр, бэлчээр ашиглалт, хөрсний үржил шимийг хамгаалсан зэрэг шалгуурыг харгалзан шалгаруулж, шагнаж урамшуулах.	2016.12.21 /2017.02.21	202	3	1	ХОХБТХ, ХХААГ
26	26	Үндэсний хөтөлбөр батлах тухай. 4.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж дүнг жил бүрийн 2 дуг аар сарын 1-ний өдрийн дотор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2016.05.02	233	4	1	ХЭЗХ
27	27	Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай: 2.1. мал аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулан баталж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах; 2.2. энэ тогтоолын хавсралтаар баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх; 2.3. сум дундын болон аймаг дундын отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан тогтоож, хэрэгжилтийг тухайн бүс нутгийн өөрөө удирдах байгууллага, хамгаалалтын захиргаадтай хамтран зохион байгуулах; 2.4. шаардлагатай зарим хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх арга хэмжээ авч, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулах;	2016.06.13	322	2	10	ХОХБТХ, НБХ, ХХААГ, ЭМГ

		2.5. малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах; 2.6. орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр худаг гаргах, бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлын явцад хийх гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах; 2.7. малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэрэг мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг малчин өрх бүрээр сайтар хангуулах; 2.8. ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийг сайтар бэлтгэж, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах; 2.9. аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түргэн тусламжийн машин, багаж хэрэгслээр дэмжлэг үзүүлэх; 2.10. орон нутагтаа болон отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаарх судалгааг үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргаж аймаг, сумын эмнэлгийг ажиллуулах.					
28	28	Төв, суурин газрын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай. 9. Эрчим хүчний үйлдвэр, компаниудын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үндсэн болон туслах тоноглолын засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах ажлыг төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд Д.Зоригт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2016.06.20	338	9	1	ХОХБТХ, ГХБХБГ, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ
	29	10. Аймгийн төв, суурин газар болон нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөний дагуу ус хангамж, ариутгах татуургын системд их болон урсгал засвар хийж, угаалга, туршилт, тохируулгын ажлыг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний дотор хийж дуусгахыг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.			10	1	
29	30	Дунд хугацааны стратеги батлах тухай. 3.Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн зорилт, арга хэмжээг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2015.10.05	396	3	1	ХОХБТХ, ХХААГ
30	31	Хөтөлбөр батлах тухай 2. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, туслам-	2015.08.24	346	2	1	ХЭЗХ

		жид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Улсын ерөнхий прокурор М.Энх-Амгалан, Авлигатай тэмцэх газрын дарга Н.Ганболд нарт зөвлөсүгэй.					
31	32	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 1.Усны сан бүхий газрын эргээс 50 метрт онцгой, 200 метрт энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг 2015 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	2015.07.07	289	1	1	ХОХБТХ, БОАЖГ, “Ундарга- Алтай” ОНӨААТҮГ
32	33	Журам батлах тухай 2. Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2015.06.29	263	2	1	ХОХБТХ, БОАЖГ
33	34	Жагсаалт батлах тухай 1.Аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд, үйл ажиллагаандаа энэ тогтоолын хавсралтаар баталсан аюултай хог хаягдлын жагсаалтыг мөрдөж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Цэнгэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2015.06.29	264	1	1	ХОХБТХ, БОАЖГ, МХГ
34	35	“Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай 2. “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын технологийн шийдэл болон гүйцэтгэлийн явц, чанар байдал, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллах.	2015.06.29	265	2	1	ХОХБТХ, ГХБХБГ, МХГ, Дэлгэр сумын ЗДТГ
35	36	Хөтөлбөр батлах тухай /удаан задардаг органик бохирдуулагчийн тухай/ 2. Үндэсний хөтөлбөрийг эрхлэх ажлынхаа хүрээнд болон тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2014.10.18	341	2	1	ХОХБТХ, БОАЖГ
36	37	Хөтөлбөр батлах тухай /хог хаягдлын менежментийг сайжруулах/ 3.Тухайн салбар, нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2014.09.18	298	3	1	ХОХБТХ, БОАЖГ
37	38	Хөтөлбөр батлах тухай 1.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн жил бүрийн төсөв болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх	2014.08.28	278	1	1	ХОХБТХ ХХААГ

		сангийн эх үүсвэрт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.					
38	39	Хөтөлбөр батлах тухай 3."Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийлэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.	2014.08.28	279	3	1	ХОХБТХ ХХААГ
39	40	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай. 3. Одоо хэрэгжиж байгаа болон хэрэгжээд дуусч байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүг дамжуулан зээлдүүлэх гэрээнд тусгасны дагуу үе шаттайгаар төлж барагдуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2014.08.07	249	3	1	ХОХБТХ “Ундарга- Алтай” ОНӨААТҮГ
40	41	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 1. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэн мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн халамж болон сэтгэл засал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байранд зуучлах зэрэг тэднийг нийгэмшүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвтөө тусган хэрэгжүүлэх .	2014.04.26	137	1	1	НБХ, ХХҮГ
41	42	Баруун бүсийн тариаланг хөгжүүлэх тухай 1."Баруун бүсийн тариаланг хөгжүүлэх, төсөл" хэрэгжүүлэхээр тогтож, үйл ажиллагааны төлөвлөгөөний 2 дахь заалт Баруун бүсэд байгаа атаршсан болон өнжөөсөн тайлбайг тариалангийн эргэлтэд оруулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 2014-2016 он 3 дахь заалт Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар бүсийн гурилын хэрэгцээг хангах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулах.	2013.11.09	366	1	1	ХОХБТХ ХХААГ
42	43	Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	2013.08.02	281	2	1	НБХ, ХХҮГ
43	44	Журам, гэрээний загвар батлах тухай 2.Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	2015.03.30	120	2	1	ХОХБТХ, МХГ, БОАЖГ
44	45	Ой зохион байгуулалт хийх журам 2.Ой зохион байгуулалтын ажлын зардлыг жил бүр улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2013.03.22	105	2	1	ХОХБТХ, БОАЖГ

		ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
45	46	ХҮИИ.5. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны улсын хэлэлцээрийн хүрээнд аймаг, салбарын түвшинд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.	2017.01.25 /2017.02.07	4	ХҮИИ.5	1	НБХ, ХХҮГ
46	47	ХҮИ.1.1.Холбогдох эрх зүйн актын заалт нэг бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй шуурхай зохион байгуулах. 2.Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” /www.unelgee.gov.mn/-нд байршуулж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээг зөв хийж тайлагнах. 3.2016 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн, хэрэгжилт нь тогтмолжсон ажлыг “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” /www.unelgee.gov.mn/-нд тэмдэглэл хийж, хяналтаас хасуулах. 4.Хууль тогтоомжид заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-г хугацаанд нь мөрдүүлэх.	2017.03.07 /2017.03.30	11	ХҮИ.1.1 -4	4	ХШҮДАХ хэлтсүүд, сум, байгууллагын дарга, эрхлэгч нар
47	48	XI.1.1. Иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг үнэн зөв, тодорхой гаргаж, хуульд заасан хугацаанд ЗГХЭГ-т ирүүлж байх. XI.1.2. Улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээг Засаг даргын зөвлөлд танилцуулсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлж байх. XI.1.3. Өргөдөл гомдлын асуудал хариуцсан албан хаагчдад тусгайлсан сургалт зохион байгуулж, үр чадварыг сайжруулах.	2017.03.29 2017.04.17	14	XI.1.1-3	3	Бүх хэлтэс, агентлаг
48	49	IV. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд 2014 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хог хаягдлын норматив тогтоох, тоо бүртгэл хийх ажлыг зохион байгуулах.	2015.06.04	33	IV	1	ХОХБТХ БОАЖГ
49	50	XXIII.2. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	2016.02.29	12	XXIII.2.	1	ХОХБТХ, ОНӨГ
	51	XXIII.3. 1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж			XXIII.3. 1-3	3	ХШҮДАХ хэлтэс, сум, албан байгуул- лагын дарга эрхлэгч нар

		үнэлэн тайлагнах; 3. Тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах; 4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх.					
50	52	XIX.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. /35 арга хэмжээнээс өөрийн хариуцсан чиг үүргийн хамаарахыг хэрэгжүүлэх/	2016.03.28	18	XIX.3.	1	ХШҮДАХ хэлтэс, сум, албан байгуул- лагын дарга эрхлэгч нар
51	53	ХҮИИ.2.2.Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангаагүй захиргааны хэм хэмжээний актыг өөрчлөх, хүчингүй болгох талаар холбогдох шийдвэр гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон холбогдох бусад төрийн байгууллагын дарга нарт;	2016.08.17	41	ХҮИИ.2.2	1	ХЭЗХ, хэлтэс, сум, албан байгуул- лагын дарга эрхлэгч нар
52	54	ХҮИИ.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов.	2016.09.28	48	ХҮИИ.2.1	1	ХОХБТХ, ОНӨГ, сум, албан байгуул- лагын дарга эрхлэгч нар
	55	ХҮИИ.2.6. Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11-д заасны дагуу ерөнхий гэрээ байгуулан, мөн хуулийн 101 дүгээр зүйл, 53.5.7-д заасны дагуу тус тус зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) болон бүх шатны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгов.			ХҮИИ.2.6.	1	
53	56	XIII.3. Харьяа байгууллагууддаа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, дотоод аудитын үйл ажиллагааг тогтмолжуулан хэвшүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулан хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	2016.10.26	52	XIII.3.	1	Бүх байгуул- лагын дарга, эрхлэгч нар
54	57	ХХҮИ.5.4. Малын гоц халдварт өвчинд тавих хяналтыг сайжруулах, өвөлжилт, хаваржилт хүндрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын бэлэн байдалд шилжиж, цаг хүндэрсэн нутаг дэвсгэрт өвөлжиж байгаа малчдад дэмжлэг, туслалцаа тогтмол үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгав.	2016.11.16	55	ХХҮИ.5.4	1	ХОХБТХ, ХХААГ, МХГ
55	58	XIII.6. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах	2016.11.30	58	XIII.6	1	ХХҮГ

		УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ					
56	59	Чиглэл өгөх тухай. 5. Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах асуудлыг Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, үүрэгжүүлж ажиллуулах	2016.03.26	09/03	5	1	НБХ, ГХБЗХГ, БСУГ
57	60	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай. /НББСШУБХ/ 3.1 Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,	2016.04.05	10	3.1	1	НБХ, ЭМГ
	61	3.2 Хүн амын эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон зөвлөгөө өгөх төвд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.			3.2		НБХ
58	62	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2.1 Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	2016.12.14	04	2.1	1	НБХ, ЭМГ
	63	2.2 Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.			2.2	1	
		ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ					
59	64	2017_03/03. Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 3.1 Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2017.01.10	03/03	1	1	ХОХБТХ БОАЖГ
	65	3.2 Орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож хамтран ажиллах талаар нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хандан уриалга гаргах			1	1	
60	66	Олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах тухай 1.Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулахдаа дараах журмыг чанд баримтлах: 1.1.Гэрээ байгуулахдаа үндэсний язгуур ашиг сонирхолыг үндэс болгох; 1.2.Гэрээг Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэх; 1.3.Гадаад харилцааны сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийн 4-т заасны дагуу гэрээ байгуулах чиглэлээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, гол хариуцлага хүлээх;	2014.09.22	46/26	1, 2, 3	7	ТЗУХ, сум, албан байгуул- лагын дарга эрхлэгч нар

		1.4.Тодорхой гэрээ байгуулах асуудлаар Гадаад харилцааны яамтай зөвшилцөн төсөл, орчуулгыг нь албан ёсоор хянуулж дүгнэлт гаргуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх; 1.5.Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.10, 5.11-д заасныг баримтлан гэрээний төслийг заавал монгол хэлээр үйлдэх. 2.Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэх. 3.Гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийхдээ "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмж болон Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгох.					
--	--	--	--	--	--	--	--

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ДОТООД, АУДИТЫН ХЭЛТЭС